

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	2.1. Оршил	4
2.2	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..	8
2.10	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
2.12	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5	Хавсралт.....	20
5.1	Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА Д.БАЯРМАНДАХ
ТАНАА

2019.02.25 № 06/261
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн дарга Д.Баярмандах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай хариуцаж хэрэгжүүлэв.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 1/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

БНСУ дахь нийгмийн хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төв нь *“БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэдэд хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээнд хоёр улсын холбогдох хуулийн дагуу хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлыг шийдвэрлэн, нийгмийн даатгалын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж монгол хүний хөгжлийг ахисан түвшинд хүргэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад төрийн үйлчилгээг шуурхай үр дүнтэй хүргэнэ.* “ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Бүгд Найрамдах Солонгос Улс дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь Монгол Улс болон Бүгд Найрамдах Сопонгсс Улс холбогдох яамдын хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд БНСУ-д ажиллаж. амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн

даатгал, нийгмийн халамж, гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр төрийн үйлчилгээг үзүүлэх, мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах, чиг үургийг хэрэгжүүлдэг.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаададаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Ахмад настны тухай хууль
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

БНСУ дахь нийгмийн хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох группын "Acolous" програм хангамжийг ашигладаг байна.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 14 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу төрийн үйлчилгээг иргэдэд чанар, хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг явуулдаг. 2018 оны санхүүгийн тайланд хийх аудитын гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлын сууриар үр дүнгийн тайлангийн зардлыг сонголоо.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны нийт зардал 1,048,101.6 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 20,962.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг харгалзан материаллаг байдлын түвшинг 2 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	950.6	
	Дүн	2	950.6	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- 2018 онд ажилтнуудын түрээсийн байрны барьцааны авлагаас ажлаас чөлөөлөгдсөн хүмүүстэй холбоотой 86,505.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагыг завсрын аудитаар өгсөн.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвөөс 2016 онд ажлаас чөлөөлөгдсөн 3 ажилтанг ажилд нь эгүүлэн томилох, ажилгүй байсан хугацааны 83,949.6 мянган төгрөгийн нөхөн олговор олгох тухай шүүхийн шийдвэр гарсан байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн САГ-2019/58/СТА-ТШЗ

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,005,272.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 79,996.7 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас шалтгаалжээ.

Байгууллагын үйл ажиллагаанаас орлого төвлөрүүлэх төсөв батлагдаагүй.

2.11 Шилэн дансны мэдээлэл

БНСУ дахь нийгмийн хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүргийн дагуу 2018 оны төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр нь цахим хуудсанд мэдээллэсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд нөлөөлж болзошгүй анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Бараа материалын тайланд 860.2 мянган төгрөгийн материалыг бөөн дүнгээр бүртгэсэн байна;

Энэ нь үнэлгээ, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 3 дахь заалтыг зөрчсөн;

2. Эрсдэл:

- Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд зөв дүнгээр бүртгээгүй байх;

3. Өгсөн зөвлөмж:

- Бараа материалыг бөөн дүнгээр бүртгэхгүй байх холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах;

4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- Санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй анхаарч ажиллана. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Ашиглалтанд байгаа 90.4 мянган төгрөгийн хангамжийн материалыг зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь үнэлгээ, хэмжилт батламж мэдэгдэлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4, "Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 2.1.4 заалтуудыг зөрчсөн тус тус зөрчсөн байна.

2. Эрсдэл:

- Хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байх;

3. Өгсөн зөвлөмж:

- Ашиглалтанд байгаа хангамжийн материалыг зардлаар бүртгэхгүй байх холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах;

4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- Санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>262,206,502.95</u>	<u>394,056,849.30</u>
33	АВЛАГА	254,240,000.00	383,985,781.13
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	90,598.19	30,281.13
335	Бусад авлага	254,149,401.81	383,955,500.00
3351	Байгууллагаас авах авлага	254,149,401.81	383,955,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,966,502.95	10,071,068.17
354	Хангамжийн материал	7,966,502.95	10,071,068.17
35410	Бичиг хэргийн материал	347,802.75	144,930.00
35420	Аж ахуйн материал	5,021,361.52	1,629,468.81
35470	Бусад хангамжийн материал	2,597,338.68	8,296,669.36
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>96,521,975.17</u>	<u>78,363,250.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	96,521,975.17	78,363,250.96
392	Биет хөрөнгө	96,521,975.17	78,363,250.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	149,111,940.16	149,111,940.16
39204	Хуримтлагдсан элэгдэл	-81,316,460.39	-101,221,603.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,439,694.12	47,348,563.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,978,444.02	-33,510,595.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,512,815.36	34,547,808.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,044,252.43	-17,912,860.84
39217	Ном	796,682.37	00.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>358,728,478.12</u>	<u>472,420,100.26</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		15500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>358,728,478.12</u>	<u>472,404,600.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	358,728,478.12	472,404,600.26
512	Хуримтлагдсан үр дүн	358,728,478.12	472,404,600.26
51210	Өмнөх үеийн үр дүн	264,602,571.35	477,228,478.12
51220	Тайлант үеийн үр дүн	94,125,906.77	-4,823,877.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>358,728,478.12</u>	<u>472,420,100.26</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	933,164,649.78	1,017,693,517.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,771,849.78	12,420,617.99
120	Нийтлэг татварын бус орлого	32,771,849.78	12,420,617.99
120002	Хүүгийн орлого	74,184.71	54,760.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,697,665.07	12,025,920.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,574,065.07	12,025,920.00
120009	Бусад орлого	00.00	339,937.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	900,392,800.00	1,005,272,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	900,392,800.00	1,005,272,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	900,392,800.00	1,005,272,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	910,715,992.36	1,024,406,194.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	910,715,992.36	1,024,406,194.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	848,534,292.58	944,409,523.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	515,837,689.24	542,772,487.07
210101	Үндсэн цалин	515,837,689.24	460,282,987.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	82,489,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,234,251.42	13,058,221.74
210201	Тэтгэврийн даатгал	7,149,069.36	9,015,957.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,021,295.77	993,658.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	817,036.41	825,361.09
210204	Ажилгүйдлийн даатгал	204,259.35	202,112.43
210205	Эрүүл мэндийн даатгал	2,042,590.53	2,021,132.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,623,948.30	248,402,161.15
210302	Түлш, халаалт	5,164,957.30	17,002,237.20
210304	Байрны түрээс	185,458,991.00	231,399,923.95
2104	Хангамж, бараа материалын зардал	49,457,774.31	56,308,045.67
210401	Бичиг хэрэг	5,667,978.34	5,738,771.45
210402	Тээвэр, шатахуун	22,979,478.42	23,552,076.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,383,041.45	20,214,373.54
210404	Ном, хэвлэл	00.00	796,682.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	405,961.00	57,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,021,315.10	5,948,192.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,339,223.00	8,736,497.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	24,530.00
210602	Тавилга	00.00	3,814,174.87
210604	Урсгал засвар	5,339,223.00	4,897,793.10
2107	Томилолт, зочны зардал	4,256,711.50	5,216,657.50
210702	Дотоод албан томилолт	4,256,711.50	5,216,657.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,749,463.85	37,166,197.94

**БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,343,916.00	8,435,665.44
210803	Даатгалын үйлчилгээ	37,027,309.02	24,184,214.90
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,652,473.00	1,336,925.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,978,325.25	1,971,840.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,747,440.58	1,237,552.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,035,230.96	32,749,254.29
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,603,430.00	7,323,240.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,431,800.96	25,426,014.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,181,699.78	79,996,671.02
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,181,699.78	79,996,671.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,383,626.00	79,996,671.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	22,448,657.42	-6,712,676.36
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	103,111,107.39	25,584,176.46
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	103,111,107.39	25,584,176.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,433,858.04	23,695,377.96
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	31,433,858.04	23,695,377.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	71,677,249.35	1,888,798.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	94,125,906.77	-4,823,877.86

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	963,301,203.16	1,005,733,530.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,908,403.16	460,630.91
120	Нийтлэг татварын бус орлого	62,908,403.16	460,630.91
120002	Хүүгийн орлого	74,184.71	54,760.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,593,600.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,593,600.00	00.00
120009	Бусад орлого	1,240,618.45	405,870.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	900,392,800.00	1,005,272,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	900,392,800.00	1,005,272,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	900,392,800.00	1,005,272,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	963,326,876.04	995,832,234.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	963,326,876.04	995,832,234.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	898,145,178.82	915,820,063.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	509,054,776.96	542,702,926.42
210101	Үндсэн цалин	422,839,726.96	460,213,426.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,215,050.00	82,489,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,980,400.90	13,013,154.40
210201	Тэтгэврийн даатгал	10,980,400.90	13,013,154.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,623,948.30	248,040,027.15
210302	Түлш, халаалт	5,164,957.30	16,949,046.70
210304	Байрны түрээс	185,458,991.00	231,090,980.45
2104	Хангамж, бараа материалын зардал	50,906,034.31	54,794,155.84
210401	Бичиг хэрэг	5,667,978.34	5,535,898.70
210402	Тээвэр, шатахуун	22,979,478.42	23,552,076.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,383,041.45	20,214,373.54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	405,961.00	57,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,469,575.10	5,433,857.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,240,413.00	5,767,583.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	901,190.00	869,790.00
210604	Урсгал засвар	5,339,223.00	4,897,793.10
2107	Томилолт, зочны зардал	4,256,711.50	5,216,657.50
210702	Дотоод албан томилолт	4,256,711.50	5,216,657.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,749,463.85	38,962,319.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,343,916.00	10,264,405.44
210803	Даатгалын үйлчилгээ	37,027,309.02	24,151,596.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,652,473.00	1,336,925.60

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,978,325.25	1,971,840.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,747,440.58	1,237,552.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,333,430.00	7,323,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,730,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,603,430.00	7,323,240.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,181,697.22	80,012,171.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,999,997.44	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,999,997.44	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,181,699.78	80,012,171.02
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,798,073.78	15,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,383,626.00	79,996,671.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-25,672.88</u>	<u>9,901,295.94</u>
14	Бусад эх үүсвэр	25,672.88	6,478,619.39
145006	Гадаад валютын ханшийн зөрүү	25,672.88	6,478,619.39
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>25,672.88</u>	<u>-9,901,295.94</u>

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	264,602,571.35	00.00	264,602,571.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	264,602,571.35	00.00	264,602,571.35
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	94,125,906.77	00.00	94,125,906.77
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	358,728,478.12	00.00	358,728,478.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	118,500,000.00	00.00	118,500,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	477,228,478.12	00.00	477,228,478.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,823,877.86	00.00	-4,823,877.86
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	472,404,600.26	00.00	472,404,600.26

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,005,272,900.00	925,276,228.98	79,996,671.02	92.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,005,272,900.00	925,276,228.98	79,996,671.02	92.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,005,272,900.00	925,276,228.98	79,996,671.02	92.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607,891,400.00	552,159,091.45	55,732,308.55	90.83
210101	Үндсэн цалин	510,926,800.00	469,669,591.45	41,257,208.55	91.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,964,600.00	82,489,500.00	14,475,100.00	85.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,428,600.00	13,013,154.40	4,415,445.60	74.67
210201	Тэтгэврийн даатгал	17,428,600.00	13,013,154.40	4,415,445.60	74.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,628,800.00	248,040,027.15	4,588,772.85	98.18
210302	Түлш, халаалт	19,404,300.00	16,949,046.70	2,455,253.30	87.35
210303	Цэвэр, бохир ус	1,339,900.00	00.00	1,339,900.00	00.00
210304	Байрны түрээс	231,884,600.00	231,090,980.45	793,619.55	99.66
2104	Хангамж, бараа материалын зардал	54,851,300.00	54,794,155.84	57,144.16	99.90
210401	Бичиг хэрэг	5,698,300.00	5,535,898.70	162,401.30	97.15
210402	Тээвэр, шатахуун	24,487,800.00	23,552,076.00	935,724.00	96.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,583,200.00	20,214,373.54	-1,631,173.54	108.78
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	406,500.00	57,950.00	348,550.00	14.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,675,500.00	5,433,857.60	241,642.40	95.74
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,803,900.00	5,767,583.10	36,316.90	99.37
210601	Багаж, техник, хэрэгсэл	903,400.00	869,790.00	33,610.00	96.28
210604	Урсгал засвар	4,900,500.00	4,897,793.10	2,706.90	99.94
2107	Томилолт, зочны зардал	6,268,400.00	5,216,657.50	1,051,742.50	83.22
210702	Дотоод албан томилолт	6,268,400.00	5,216,657.50	1,051,742.50	83.22
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,077,000.00	38,962,319.54	14,114,680.46	73.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,536,000.00	10,264,405.44	1,271,594.56	88.98
210803	Даатгалын үйлчилгээ	30,609,300.00	24,151,596.50	6,457,703.50	78.90

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,497,500.00	1,336,925.60	3,160,574.40	29.73
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,980,000.00	1,971,840.00	8,160.00	99.59
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,454,200.00	1,237,552.00	3,216,648.00	27.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7323500.00	7323240.00	260.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,323,500.00	7,323,240.00	260.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,005,272,900.00	1,005,272,900.00	00.00	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,005,272,900.00	1,005,272,900.00	00.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,005,272,900.00	1,005,272,900.00	00.00	100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14	12	2	86
620001	Удирдах ажилтан	2	2	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	12	10	2	83

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Огноо:

2019/02/22

Аудитын нэр:

БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит

Аудитын код:

САГ-2019/58/ СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5			9	10
1	Бараа материалын тайланд 860.2 мянган төгрөгийн материалыг бөөн дүнгээр бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 3 заалтыг зөрчсөн;	860.2	Зөвлөмж өгсөн	2/22/2018	1	Дарга Мэргэжил тэн	Д.Баярмандах Х.Золгэрэл
2	Ашиглалтанд байгаа 90.4 мянган төгрөгийн хангамжийн материалыг зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4, "Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 2.1.4 заалтуудыг зөрчсөн";	90.4	Зөвлөмж өгсөн	2/22/2018	1	Дарга Мэргэжил тэн	Д.Баярмандах Х.Золгэрэл
3	Ажилтануудын түрээсийн байрны барьцаатай холбоотой авлагаас ажлаас чөлөөлөгдсөн хүмүүстэй холбоотой 86,505.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн;	86,505.0	Албан шаардлага өгсөн	2/22/2018	1	Дарга Мэргэжил тэн	Д.Баярмандах Х.Золгэрэл
Нийт		87,455.6					

